



ХАСБАНК ХК-ИЙН 2024 ОНЫ III УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ҮР ДҮН

2024 оны 10 сарын 14

Агуулга

Онцлох үйл явдал	3-4
2024 оны III улирлын санхүүгийн үр дүн	5-8
Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлт	9-10

Онцлох үйл явдал

2024 оны III улирал

ХасБанк Хятадын Хөдөө аж ахуйн банктai хамтран Хятад-Монголын байгууллагуудын хил дамнасан Дижитал төлбөрийн шийдлийн хамтын ажиллагааны төслийг хэрэгжүүлэхээр болж, санамж бичигт гарын үсэг зурлаа. Энэхүү төсөл хэрэгжсэнээр ХасБанкны харилцагчид өөр ямар нэг аппликейшн суулгаж, цэнэглэх шаардлагагүйгээр ХасБанкны дижитал аппараа Хятад улсын аль ч системийн QR кодыг уншуулан төлбөр тооцоогоо аюулгүй, хурдан хийх бололцоо бүрдэх юм.

ХасБанк Монголбанкны Үндэсний төлбөрийн системийн тухай хууль болон холбогдох журмуудыг үндэслэн **“Төлбөрийн картын клирингийн систем”** ажиллуулах зөвшөөрлийг Монголбанкнаас авлаа. Төлбөрийн картын клирингийн системийн зөвшөөрөл авснаар Монгол Улсад төлбөрийн үйлчилгээ эрхлэгч байгууллагууд буюу бусад арилжааны банкууд болон ББСБ-ууд, финтек компаниудын хоорондын картын төлбөр тооцоог дамжуулж, клиринг хийх үйлчилгээг үзүүлэх бүрэн боломжтой боллоо.

Ногоон технологи 2024 өдөрлөгт оролцож, жилийн 6%-ийн хүүтэй Эко хэрэглээний зээлээ сурталчилснаас гадна, эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуур, дулаалгын шийдлүүд сонирхож буй харилцагчдад газар дээр нь бүтээгдэхүүнээ сонгон зээлээр авах нөхцөлийг бүрдүүллээ.



Онцлох үйл явдал

2024 оны III улирал

ХасБанк Оюу толгой компанийн дэргэдэх **Ханбогдын хөгжлийн хурдасгуур Оюу толгойн сантай хамтран** бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр болж, хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурлаа. Хөтөлбөрийн хүрээнд тус сангийн хөрөнгө оруулалтаар ХасБанк Ханбогд суманд үйл ажиллагаа явуулж буй болон явуулах төлөвлөгөөтэй бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох төдийгүй, төслийн хүрээнд бизнесийн тогтвортой өсөлтийг хангах сургалт, мэдээлэл, зөвлөх үйлчилгээ үзүүлэх боломжтой юм.

Fitch Ratings агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулахтай зэрэгцээд **ХасБанкны зээлжих зэрэглэлийг мөн В+ (тогтвортой)** болгож нэг шатлалаар ахиуллаа.

Ажилтнуудынхаа ажил амьдралын тэнцвэрт байдлыг хангаж, илүү чөлөөтэй, урам зоригтой ажиллах боломжийг бүрдүүлэх зорилгоор **ХасБанк өдрийн ажлын цагийг 1 цагаар богиносгон 7 цаг болгож** 9-р сарын туршид туршилтаар хэрэгжүүллээ. Уг зохицуулалтын үр дүнд ажилтнуудын сэтгэл ханамж өндөр байж, ажлын бүтээмжид эергээр нөлөөлж буйг харгалзан ХасБанк ажлын 7 цагийн горимыг 2024 он дуустал үргэлжлүүлэхээр шийдвэрлэлээ.



ХасБанкны зээлжих зэрэглэл

"В+/ТОГТВОРТОЙ"
болж сайжирч ажиллана



Санхүүгийн үр дүн



2024 оны III улирал

ROE*	Цэвэр ашиг
26.2%	₮128.7 тэрбум

EPS	ХАС
₮122.3	₮761

1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлт
18.2%	34.5%

Онцлох үзүүлэлтүүд:

- 2024 оны III улирлын **татварын дараах цэвэр ашиг 43.4 тэрбум төгрөгт** хүрч өмнөх улирлаас +0.4% өссөн байна. Өссөн дүнгээр 2024 оны 9 сарын 30-ны байдлаарх татварын дараах цэвэр ашиг 128.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 26.7% өссөн байна;
- **Зээл болон санхүүгийн түрээсийн багц өмнөх улирлаас 8.9% өссөн бол оны эхнээс 31.2% өссөн байна.** Сегментээр задлан харвал: хэрэглээний зээл (өмнөх улирлаас +12%, оны эхнээс +39%), ипотекийн зээл (өмнөх улирлаас +8%, оны эхнээс +57%), санхүүгийн түрээс (өмнөх улирлаас +11%, оны эхнээс +29%), Бичил жижиг дунд бизнесийн зээл (өмнөх улирлаас +4%, оны эхнээс +26%), байгууллагын зээл (өмнөх улирлаас +13%, оны эхнээс +31%) тус тус өссөн байна;
- Активын чанар сайн хэвээр буюу нийт **багцад эзлэх чанаргүй зээлийн үлдэгдэл 2.2% байна;**
- Нийт харилцах болон хадгаламж III улиралд тогтвортой байсан бол **оны эхнээс 11.3% өссөн** байна.;
- Оны эхний хагас жилийн цэвэр ашгаас 18.9 тэрбум төгрөг ногдол ашиг тараасны дараагаар **1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 18.2%** (доод шаардлага 12.5%-с их) болсон байна;
- 2024 оны 9 сарын 19-ны өдрөөс эхлэн Банк өөрийн хувьцааг эргүүлэн худалдан авах хөтөлбөр хэрэгжүүлж байгаа ба хөтөлбөрийн хүрээнд нийт 1.75 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 2.3 сая ширхэг хүртэлх хувьцааг эргүүлэн худалдан авах боломжтой. 2024 оны 9 сарын 30-ны байдлаар нийт 154,996 ширхэг хувьцааг эргүүлэн худалдан авсан байна;
- Төлбөр түргэн гүйцэтгэх харьцаа үзүүлэлт 34.5% (доод шаардлага 25%-с их);
- Бусад Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд зохистой хэм хэмжээнд байна.

Тайлбар: *ROE буюу “Өөрийн хөрөнгийн өгөөж”-ийг тооцохдоо тухай улирлын татварын дараах цэвэр ашгийг тухай улирлын дундаж өөрийн хөрөнгийн үлдэгдэлд харьцуулан тооцсон.


Санхүүгийн үзүүлэлтийн тренд



2024 оны III улирал


Цэвэр ашиг

Тэрбум төгрөг



ROE*


Дундаж өөрийн хөрөнгөд суурилсан



Ногдол ашиг


Тэрбум төгрөг

IPO хийснээс хойш
₮61.0 тэрбум



Нийт актив

Тэрбум төгрөг



1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа



Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа



Тайлбар: *ROE буюу “Өөрийн хөрөнгийн өгөөж”-ийг тооцоходоо тухай улирлын татварын дараах цэвэр ашгийг тухай улирлын дундаж өөрийн хөрөнгийн үлдэгдэлд харьцуулан тооцсон.

Зээлийн үйл ажиллагаа



2024 оны III улирал

Зээлийн багц

₮3,609 Тэрбум

Зээлийн тоо


176K ▲ +7.6k Өмнөх улирлаас

Цахим зээлийн тоо

110K ▲ +7.8k Өмнөх улирлаас

Нийт зээл

Тэрбум төгрөг



Сегментээр

Тэрбум төгрөг



Нэмэлт мэдээлэл:

- Эдийн засгийн нөхцөл байдал сайн байгаа нь Банкны зээлийн багц сегмент бүрээр жигд өсөхөд нөлөөлсөн байна;
- Цахим зээлийн олголт болон процессын автоматжуулалт нэмэгдсэн нь иргэдийн зээлийн багцын өсөлтөд голчлон нөлөөлсөн байна;
- Зээлийн шугам ашиглалт улирлын чанартай нэмэгдсэн нь Корпорэйт банкны зээлийн багц III улиралд 13.1% өсөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Гадаад эх үүсвэр

2024 оны III улирал

- Тайлант хугацаанд гадаад эх үүсвэрийн хуваарьт эргэн төлбөр хийгдсэнээр гадаад эх үүсвэрийн үлдэгдэл өмнөх улирлаас 1.9%-р буурсан байна;
- Банк 2024 оны эх үүсвэрийн төлөвлөгөөний дагуу гадаад банк санхүүгийн байгууллагуудтай шинэ эх үүсвэрийн хэлцэл хийж буй бөгөөд 2024 оны 10-11 саруудад шинэ эх үүсвэрийн олголт хийгдэх төлөвтэй байна.



Олон улсын түнш банк, санхүүгийн байгууллагууд:



Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан



1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт (Tier I)

18.2%

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлт (Liquidity)

34.5%



39.4 Бэлэн мөнгө

947.9



ТБҮЦ

526.0



Монголбанканд байршуулсан хөрөнгө

166.2

BBB-" ба түүнээс дээш үнэлгээтэй гадаадын СБ-д байршуулсан хөрөнгө

2.9 Бусад

Түргэнборлогдох актив : ₮1,682.4 тэрбум

Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан - үргэлжлэл

Тусгайлан өөрөөр заагаагүй бол хувиар (%) илэрхийлэв	2023 III улирал	2023 IV улирал	2024 I улирал	2024 II улирал	2024 III улирал
Гадаад валютын нээлттэй позиц (нэгж валютаар) +/-15%	4.3%	-1.3%	-1.9%	-2.3%	-6.2%
Гадаад валютын нээлттэй позиц (нийт валютаар) +/-30%	4.8%	-1.4%	-2.9%	-3.3%	-9.1%
Нийт томоохон зээлдэгчдэд олгох активын төвлөрлийн харьцаа <300%	23.6%	38.6%	33.0%	52.9%	56.9%
Үндсэн хөрөнгө, нийт хөрөнгийн харьцаа <8%	1.6%	1.3%	1.4%	1.2%	1.2%
Хадгаламжийн төвлөрлийн харьцаа <25%	6.9%	7.8%	7.8%	7.9%	7.4%

Тусгайлан өөрөөр заагаагүй бол хувиар (%) илэрхийлэв	2023 III улирал	2023 IV улирал	2024 I улирал	2024 II улирал	2024 III улирал
Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй):					
Банкны нийт хувьцаа эзэмшигчид	1.3%	0.8%	0.9%	0.7%	1.7%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.1%	0.1%	0.1%	0.1%	0.1%
Банкны бусад холбогдох этгээд	3.6%	3.2%	3.0%	2.9%	2.8%
Банкны нийт холбогдох этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй)					
Банкны нийт хувьцаа эзэмшигчид	1.4%	0.9%	0.9%	0.7%	1.7%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.3%	0.3%	0.3%	0.5%	0.4%
Банкны бусад холбогдох этгээд	3.6%	3.2%	3.0%	2.9%	2.8%



 <https://www.xacbank.mn>

 InvestorRelation@xacbank.mn

 (976)-75771888-(888)